



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/173

Булган сум

### Шууд худалдан авах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "ГХБХБГ-ын иргэдэд үйлчлэх түргэн үйлчилгээний киоск машин худалдан авах (1ш)" нийлүүлэгчээр "Эрхэт инноваци" ХХК-тай 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавин хүлээн авч, данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Эрхэт инноваци" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Галмандах)-д даалгасугай.

4. Тус барааг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010254